



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 7 нэрийн нийт 90,086,723.57 (ерэн сая наян зургаан мянга долоон зуун хорин гурван төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 35,767,498.00 (гучин таван сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун ерэн найман) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

132001430

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт

Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй,  
ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалта д орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Шкаф	3/21/2011	247,000.00	1	247,000.00	74,100.00	1	74,100.00	2
2	Ширээ	6/22/2011	175,000.00	5	875,000.00	52,500.00	5	262,500.00	2
3	Хувцасны шкаф	6/22/2011	230,000.00	4	920,000.00	69,000.00	4	276,000.00	2
4	Шкаф	9/30/2008	300,000.00	1	300,000.00	90,000.00	1	90,000.00	2
5	Шкаф	6/6/2011	329,900.00	1	329,900.00	98,970.00	1	98,970.00	2
6	Дотуур холбооны станц	12/31/2015	36,919,403.21	1	36,919,403.21	14,767,760.00	1	14,767,760.00	2
7	Сервер компьютер	12/31/2015	50,495,420.36	1	50,495,420.36	20,198,168.00	1	20,198,168.00	2
	<b>Нийт дүн</b>			<b>14</b>	<b>90,086,723.57</b> (ерэн сая наян зургаан мянга долоон зуун хорин гурван төгрөг тавин долоон мөнгө)		<b>14</b>	<b>35,767,498.00</b> (гучин таван сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун ерэн найман)	